

# “ГТХЗНТ” УТУГ-ЫН ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2018-09-20

## Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

“ГТХЗНТ” УТУГ-ын үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүн, үр нөлөө, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулах, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал зөвлөмж боловсруулах, удирдлагыг холбогдох мэдээллээр хангах зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

## Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан “Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж, дүгнэх журам”, “ГТХЗНТ” УТУГ-ын захирлын 2018 оны А/04 дүгээр тушаалаар батлагдсан ГТХЗНТ-ийн хяналт-шинжилгээ, үнэлгээний журамд заасан аргачлалын дагуу гүйцэтгэв.

2018 оны үр дүнгийн гэрээ, үйл ажиллагааны хагас жилийн болон бүтцийн нэгжүүдийн төлөвлөгөөний биелэлт, тушаал шийдвэр, түүний хэрэгжилтийн байдал, холбогдох тайлан, бусад баримт бичгийг үндсэн материал болгон ашиглаж, хариуцан хэрэгжүүлэх болон нэгтгэж өгсөн ажилтнаас лавлаж тодруулсаны үндсэн дээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.

## Гурав. Үнэлэлт

Төсвийн ерөнхийлөн захирагчтай 2018 онд байгуулсан үр дүнгийн гэрээнд нийт 47 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100%-ийн биелэлттэй 31, 90%-ийн биелэлттэй 1, 70%-ийн хэрэгжилттэй 2, 50%-ийн хэрэгжилттэй 5, 30%-ийн хэрэгжилттэй 8 арга хэмжээтэй, хэрэгжилт 81,3%-тай байна.

Хүснэгт 1

Арга хэмжээ	Тоо	Хэрэгжилтийн түвшин							Биелэлт ийн дүн /хувиар/
		100	90	70	50	30	0	0	
Нийт арга хэмжээ	29	17	1	1	3	7	-	-	<b>76,55</b>
Тусгай захиалгат арга хэмжээ	5	1	-	1	2	1	-	-	<b>60,00</b>
Манлайллын зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	13	13	-	-	-	-	-	-	<b>100</b>
<b>Бүгд</b>	<b>47</b>	<b>31</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>5</b>	<b>8</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>81,28</b>

## Үр дүнгийн гэрээнд дараах арга хэмжээ удаашралтай байна:

1.1.1. Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах санал боловсруулж, ЗТХЯ-нд хүргүүлэх;

1.1.4. Төмөр замын ачааны вагоны үйлдвэрлэлийн объект ТВ 10031-2009 стандартыг орчуулан боловсруулах;

2.1.2. Галт тэрэгний хөдөлгөөний 2018-2019 оны өвлийн нэгдсэн зурмаг боловсруулж, батлах;

2.3.2. Хөдлөх бүрэлдэхүүн бүртгэлийн програм хангамжийг боловсронгуй болгох арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

2.3.4. “БТЕГ” ХХК-ийн төмөр замын мэдээллийн сүлжээнд холбогдох;

2.3.5. “МТЗ” ТӨХК-ийн төмөр замын мэдээллийн сүлжээнд холбогдох;

2.3.6. Төмөр зам болон авто зам хоорондын логистикийн уялдаа холбооны талаар судалгаа хийж, санал боловсруулах;

2.4.1. ГТХЗНТ-ийн барилгад суурилуулах тоног төхөөрөмж, техникийн шийдэл боловсруулах;

2.5.1. Суурь бүтцүүдийн хөдөлгөөнийг хөдлөх бүрэлдэхүүний тусламжтай хянах ажиллагааг автоматжуулах санал, шийдэл боловсруулах;

3.1.1. Төмөр замын тээврийн салбарын мэргэшсэн, зөвлөх инженер, бүтээлүүдээр мэдээллийн сан үүсгэх;

3.1.2. Төмөр замын тээврийн салбарт мөрдөгдөх олон улсын болон Европын холбооны стандартуудыг орчуулан боловсруулах;

2.3.1. Улсын хэмжээнд ашиглагдаж буй хөдлөх бүрэлдэхүүн, салбар замын нэгдсэн тооллого, бүртгэл хийх ажлыг зохион байгуулах;

2.3.7. Суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч нарын саналыг нэгтгэн зохицуулалт хийх, монголын талаас зохион байгуулалттай нэгдмэл саналыг ТЗХАБ-ын зөвлөгөөнөөр дэвшүүлж, шийдвэрлүүлж байх зорилгоор Монгол-Орос, Монгол-Хятадын хилийн төмөр замын хамтарсан комиссын болон экспорт, импорт, транзит ачааны хэмжээг тохиролцох ТЗХАБ-ын 2017-2018 оны хуралд ажиглагчаар оролцох;

3.2.1. ГТХЗНТ-ийн Техник эдийн засгийн үндэслэл, барилгын зураг төслийн санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх;

3.2.2. ЗТХЯ, ГТХЗНТ, Далайн захиргааны албан хаагчдын орон сууц, Төв, ДЗ-ны оффисын барилгын зураг төслийн ажил боловсруулахад захиалагчийн хяналт тавих, барилга угсралтын ажлын гүйцэтгэгч, санхүүжүүлэх банкныг сонгож барилга угсралтын ажлыг эхлүүлэх, шаардлагатай техникийн нөхцөлүүдийг авах, инженер геологийн дүгнэлт хийлгэх.

## **Дөрөв. Дүгнэлт**

1/ Төсвийн ерөнхийлөн захирагчтай “ГТХЗНТ” УТҮГ-ын төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээний хэрэгжилт 2018.09.20-ны өдрийн байдлаар 81,3 хувийн биелэлттэй байгаа нь 2018 оны эхний хагас жилийн байдлаас 8,2 хувиар өссөн дүнтэй байна.

2/ Үр дүнгийн гэрээнд нийт 15 арга хэмжээний хэрэгжилт удаашралтай байгаагийн ... нь Хөдөлгөөн зохицуулалт, хөдлөх бүрэлдэхүүний хэлтсийн, ... нь Технологи, мэдээлэл, сургалт, судалгааны хэлтсийн, ... нь нэгжүүд хамтарч хариуцан хэрэгжүүлэх ажлууд байна.

3/ Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах санал боловсруулж, ЗТХЯ-нд хүргүүлэх арга хэмжээний тухайд хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын төсөл батлагдаагүй гэх шалтгаанаар төвийн Захирлын тушаалаар 2017 онд байгуулагдсан ажлын хэсэг хуралдаагүй, өөрөөр хэлбэл ажиллаагүй байна.

4/ Төмөр замын ачааны вагоны үйлдвэрлэлийн объект ТВ 10031-2009 стандартыг орчуулан боловсруулах арга хэмжээний тухайд хариуцсан ажилтан өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн, тус арга хэмжээний хэрэгжүүлэх хугацаа нь “**9-10 сар**” байсантай холбогдуулан “76 хуудас стандартаас 46 хуудсыг орчуулсан, орчуулгын найруулгыг хянаж байна”, мөн “хугацаа болоогүй” гэж тайлагнаж байсантай холбогдуулан цалгардаж, удааширсан гэж үзэж байна. Одоогоор хятад хэлтэй мэргэжилтэй ажилтан байхгүйгээс орчуулгын ажилд хүндрэл учирч байна.

5/ Галт тэрэгний хөдөлгөөний 2018-2019 оны өвлийн нэгдсэн зурмаг боловсруулж, батлах, Хөдлөх бүрэлдэхүүн бүртгэлийн програм хангамжийг боловсронгуй болгох арга хэмжээ авч хэрэгжүүлэх, ... салбар замын нэгдсэн тооллого, бүртгэл хийх ажлыг зохион байгуулах арга хэмжээний тухайд Захирлын шуурхай зөвлөгөөнөөс хариуцсан нэгж, ажилтанд хугацаатай үүрэг даалгавар өгөгдөж, тодорхой ажлууд хийгдэж байна.

6/ “БТЕГ” ХХК-ийн төмөр замын мэдээллийн сүлжээнд холбогдох, “МТЗ” ТӨХК-ийн төмөр замын мэдээллийн сүлжээнд холбогдох арга хэмжээний хэрэгжүүлэх хугацаа нь “**7-8 сар**” гэж тусгагдсан бөгөөд нэгжүүдийн ажлын уялдаа холбоогүй байдал, төлөвлөлтийн алдаа, удирдлагаас чиглэл, зөвлөмж аваагүй, хэрхэн хэрэгжүүлэх талаар зөвлөлдөөгүйгээс удааширсан гэж дүгнэлээ.

7/ Төмөр зам болон авто зам хоорондын логистикийн уялдаа холбооны талаар судалгаа хийж, санал боловсруулах арга хэмжээний тухайд хариуцсан ажилтан 3 дугаар сард ТМССХ-т сэлгэн ажилласан, 6 дугаар сард захиргааны чөлөө авсан, 8 дугаар сард тээврийн хөгжлийн мэргэжилтнээр шилжиж, удаан хугацааны акттай байсан, 9 дүгээр сараас үргэлжлүүлэн урт хугацааны цалингүй чөлөө авсан нь тус ажлыг цалгардуулах гол шалтгаан болсон, түүнчлэн өмнө ажиллаж байсан нэгжийн дарга тус арга хэмжээнд анхаарч ажиллаагүйгээс хэрэгжилт хангалтгүй байна.

8/ ГТХЗНТ-ийн барилгад суурилуулах тоног төхөөрөмж, техникийн шийдэл боловсруулах, Суурь бүтцүүдийн хөдөлгөөнийг хөдлөх бүрэлдэхүүний тусламжтай хянах ажиллагааг автоматжуулах санал, шийдэл боловсруулах арга хэмжээний хэрэгжүүлэх хугацаа “7-8 сар”, “санал гаргаж, шийдэл боловсруулж ЗТХЯ-нд танилцуулсан байна” гэсэн зорилтот түвшиндээ хүрээгүй удаашралтай байна.

9/ Төмөр замын тээврийн салбарын мэргэшсэн, зөвлөх инженер, бүтээлүүдээр мэдээллийн сан үүсгэх арга хэмжээний тухайд хариуцсан нэгжийн 3, 4, 5, 6, 7, 9 дүгээр сарын ажлын төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг 100% гэж тайлагнаж байсан хэдий ч өнөөг бодитой үр дүн харагдахгүй байна.

10/ Төмөр замын тээврийн салбарт мөрдөгдөх Олон Улсын болон Европын холбооны стандартуудыг орчуулан боловсруулах арга хэмжээний тухайд тайлант оны 1-3 сард орчуулах, боловсруулах ажил хийгдсэн хэдий ч гадаад хэлний мэдлэгийн түвшнээс шалтгаалж орчуулга шаардлага хангаагүй, хянан засварлах ажил удааширсан, 5 дугаар сараас тухайн ажлыг төлөвлөгөөнд тусгалгүй орхигдуулж, анхаарал хандуулаагүй улмаас хэрэгжилт удааширсан гэж үзэж байна.

## **Тав. Санал зөвлөмж**

1. Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах санал боловсруулж, ЗТХЯ-нд хүргүүлэх, Галт тэрэгний хөдөлгөөний 2018-2019 оны өвлийн нэгдсэн зурмаг боловсруулж, батлах, Хөдлөх бүрэлдэхүүн бүртгэлийн програм хангамжийг боловсронгуй болгох арга хэмжээ авч хэрэгжүүлэх, ... салбар замын нэгдсэн тооллого, бүртгэл хийх ажлыг зохион байгуулах, ГТХЗНТ-ийн барилгад суурилуулах тоног төхөөрөмж, техникийн шийдэл боловсруулах, Төмөр замын тээврийн салбарын мэргэшсэн, зөвлөх инженер, бүтээлүүдээр мэдээллийн сан үүсгэх гэсэн 6 арга хэмжээг зорилтот түвшин, үр дүнд хүргэх бололцоотой байгаа тул хариуцсан нэгж, ажилтнууд ажил эрчимжүүлэх тухай Захирлын тушаалыг мөрдлөг болгож бүрэн хэрэгжүүлж дуусгах;

2. Төмөр замын ачааны вагоны үйлдвэрлэлийн объект ТВ 10031-2009 стандартыг орчуулан боловсруулах, “БТЕГ” ХХК-ийн төмөр замын мэдээллийн сүлжээнд холбогдох, “МТЗ” ТӨХК-ийн төмөр замын мэдээллийн сүлжээнд холбогдох, Төмөр зам болон авто зам хоорондын логистикийн уялдаа холбооны талаар судалгаа хийж, санал боловсруулах, Суурь бүтцүүдийн хөдөлгөөнийг хөдлөх бүрэлдэхүүний тусламжтай хянах ажиллагааг автоматжуулах санал, шийдэл боловсруулах, Төмөр замын тээврийн салбарт мөрдөгдөх Олон Улсын болон Европын холбооны стандартуудыг орчуулан боловсруулах гэсэн 6 арга хэмжээний хэрэгжилтийн түвшинг ахиулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх, зохион байгуулах. Тухайлбал, нөөцөө зөв хуваарилж ачааллыг жигдрүүлэх, нэмэлт үүрэг өгөхгүй байх, ажлын цаг ашиглалт, ажлын гүйцэтгэлд нь хяналт тавих, хугацаатай үүрэг өгч биелэлтийг хангуулах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, урам дэм өгөх, сайшаах зэргээр идэвхжүүлэх;

3. УБ хотноо 2018.09.10-14-нд зохион байгуулагдсан Төмөр замын хамтын ажиллагааны байгууллагын “Төмөр замын 2-р бүлгийн зорчигчийн галт тэрэгний хөдөлгөөний хуваарь /зурмаг/ боловсруулах, зөвшилцөх” хурлын тэмдэглэл /протокол/-ийг албан хэрэгцээнд авах, судлах;

4. БНСУ-ын “КОАЙКА” Олон Улсын хамтын ажиллагааны байгууллагаас хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрт хамруулахаар хүргүүлсэн ГТХЗНТ-ийн Техник-эдийн засгийн үндэслэл, техникийн зөвлөх үйлчилгээний болон ГТХЗНТ-ийн барилга барих, тоног төхөөрөмж суурилуулах төслийн асуудлаар яамны ТЗДТБХЗГ-ын хариуцсан мэргэжилтэнтэй ажлаа зөв ойлгуулах, дэмжүүлэх талаар холбогдох, асууж лавлах, холбоотой ажиллах;

5. ЗТХЯ, ГТХЗНТ, Далайн захиргааны албан хаагчдын орон сууц, Төв, ДЗ-ны оффисын барилгын ажил, ЗТХ-ийн сайдын 2017 оны 39 дүгээр тушаалын хэрэгжилтийн асуудлаар Зам, тээврийн хөгжлийн Дэд сайдаас дэмжлэг, чиглэл авах, шаардлагатай бол холбогдох мэдээллийн хамтаар албан бичиг хүргүүлэх, хариу авах.

### **ТАНИЛЦСАН:**

“ГТХЗНТ” УТҮГ-ЫН ЗАХИРАЛ

Т.АРИУНБААТАР

ХЗХБХ-ИЙН ДАРГА

Ц.ОЮУНБАТ

ТМССХ-ИЙН ДАРГА

Б.ЭНХЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН:  
ХШҮДАХА

Э.ОСОРЖАМАА